

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/35/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.24. № 01/63

танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
Д.ТҮМЭНБАЯР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаан-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Цагаан-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

- ❖ Байгал орчин нөхөн сэргээх зардлаас гадаад аяллын зардалд 4,654.1 мянган төгрөг зарцуулсан байна.
- ❖ Мод тарих ажил гүйцэтгээгүй Агар Тэс Эрдэнэ ХХК-д 1,940.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.
- ❖ Монгол Улсын Засгийн газраас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалд ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй, тэнцээгүй томилогдсон этгээдийг олж тогтоон чөлөөлөх чиглэлийн дагуу чөлөөлөгдсөн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Б.Мягмаржав-д 3,136.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.
- ❖ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 2,050.0 мянган төгрөгийн ажилчдын шинэ жилийн бэлэг, бялуу худалдан авч, зарцуулсан байна.
- ❖ Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт хөтөлбөрийн төсвийг төлөвлөх, зарцуулахдаа багийн төвийн өдөрлөг арга хэмжээний зардал гэж 6,000.0 мянган төгрөгийн тэмцээн уралдаан зохион байгуулж, өргөмжлөл, шагнал, медаль гардуулах зэрэг үр ашиггүй зардал төлөвлөж, зарцуулж байна.

6724040099

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-т нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлийг материаллаг хэмжээний зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 2,790.8 мянган төгрөгөөр давсан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 10,645.6 мянган төгрөгөөр буурсан нь Цагаан-Уул сумын ИТХ-ын 2023 оны 05 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг акталсан, мөн тооллогоор дутагдсан хөрөнгийг данснаас хасаж авлагаар тусгасантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

Цагаан-Уул сумын ЗДТГ-ын дотоод хяналтын нэгж нь тайлант онд ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Цагаан-Уул сумын ЗДТГ нь тайлант онд 5 зорилт, 100 ажил, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг өөрийн үнэлгээгээр 100 хувь хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>189,704,174.91</u>	<u>284,021,419.00</u>
33	АВЛАГА	00.00	10,496,041.00
335	Бусад авлага	00.00	10,496,041.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	8,329,500.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	2,166,541.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	1,985,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	1,985,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	189,704,174.91	271,540,378.00
354	Хангамжийн материал	185,674,174.91	269,075,378.00
35410	Бичиг хэргийн материал	3,554,488.00	2,492,378.00
35420	Аж ахуйн материал	61,570,551.91	123,876,265.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,320,000.00	3,320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	7,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	5,624,600.00	23,284,350.00
35460	Хүнсний материал	10,000.00	17,500.00
35470	Бусад хангамжийн материал	111,587,535.00	116,084,885.00
35600	Мал амьтад	4,030,000.00	2,465,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,167,727,731.14</u>	<u>1,154,028,827.39</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,167,727,731.14	1,154,028,827.39
392	Биет хөрөнгө	983,489,981.19	970,372,327.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	817,445,315.80	858,845,317.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	-277,483,384.04	-320,607,944.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	282,668,311.00	355,668,311.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-164,600,592.65	-211,153,938.45
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	257,236,191.00	260,354,291.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-123,219,382.01	-151,492,575.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,073,700.00	88,724,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,180,286.26	-42,956,999.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	244,190,078.40	257,260,078.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-103,639,970.05	-124,268,311.89
393	Биет бус хөрөнгө	184,237,749.95	183,656,499.92
39301	Программ хангамж	3,185,000.00	3,185,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,466,250.05	-3,047,500.08
39303	Бусад биет бус хөрөнгө	183,519,000.00	183,519,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,357,431,906.05</u>	<u>1,438,050,246.39</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,357,431,906.05</u>	<u>1,438,050,246.39</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,357,431,906.05	1,438,050,246.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	703,146,831.77	703,146,831.77
51101	Өмч: - төрийн	703,146,831.77	703,146,831.77
512	Хуримтлагдсан үр дүн	419,883,837.79	502,530,718.13
51210	Өмнөх үеийн үр дүн	419,883,837.79	421,912,377.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	80,618,340.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,401,236.49	232,372,696.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,357,431,906.05</u>	<u>1,438,050,246.39</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>1,208,511,845.40</u>	<u>1,226,999,832.35</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>370,277,025.40</u>	<u>204,833,813.63</u>

120	Нийтлэг татварын бус орлого	370,277,025.40	204,833,813.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	370,277,025.40	204,833,813.63
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,629,900.00	3,514,500.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	327,765,167.40	136,976,576.63
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	36,881,958.00	64,342,737.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	838,234,820.00	1,022,166,018.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,138,320.00	43,883,418.72
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,720,000.00	87,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,268,400.00	23,106,242.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,149,920.00	5,690,176.72
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	821,096,500.00	978,282,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	821,096,500.00	978,282,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	944,727,094.59	1,144,132,062.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	817,650,894.59	1,138,085,062.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	668,279,510.66	1,053,405,155.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,711,640.46	475,469,611.48
210101	Үндсэн цалин	213,019,630.46	311,502,780.60
210102	Нэмэгдэл	45,099,196.00	110,004,820.31
210104	Урамшуулал	18,592,814.00	53,962,010.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,651,476.00	59,531,733.05
210201	Тэтгэврийн даатгал	23,840,043.00	40,625,688.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,804,709.00	4,779,492.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,193,368.00	3,819,194.35
210204	Ажилгүйдлийн даатгал	528,487.00	937,016.17
210205	Эрүүл мэндийн даатгал	5,284,869.00	9,370,341.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,380,495.07	69,970,338.88
210301	Гэрэл, цахилгаан	4,478,203.07	11,074,239.85
210302	Түлш, халаалт	54,998,192.00	57,385,599.00
210303	Цэвэр, бохир ус	904,100.00	1,510,500.03
2104	Хангамж, бараа материалын зардал	64,601,868.94	116,227,427.12
210401	Бичиг хэрэг	6,295,874.00	6,553,210.00
210402	Тээвэр, шатахуун	32,157,465.00	55,652,388.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,800,701.00	4,027,568.61
210404	Ном, хэвлэл	248,000.00	176,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,463,662.94	10,696,548.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,040,666.00	983,817.91
210408	Бараа материал акталсны зардал	595,500.00	8,101,994.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	30,035,500.00
2105	Нормативт зардал	510,000.00	480,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	510,000.00	480,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,261,250.00	12,538,317.00
210604	Урсгал засвар	19,261,250.00	12,538,317.00
2107	Томилолт, зочны зардал	2,892,200.00	3,395,000.00

210702	Дотоод албан томилолт	2,892,200.00	3,395,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,714,448.60	33,418,627.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,764,605.60	31,220,816.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	580,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	448,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,994.00	308,830.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	89,769.00	67,344.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	726,000.00	395,000.00
210807	Газрын төлбөр	394,080.00	396,637.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	187,556,131.59	282,374,100.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,599,214.50	111,992,250.05
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,240,875.00	1,280,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,716,042.09	169,101,850.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,371,383.93	84,679,907.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,874,000.00	12,544,319.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,374,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	5,920,959.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,499,500.00	6,623,360.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,497,383.93	72,135,588.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115,497,383.93	72,135,588.05
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	127,076,200.00	6,047,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	127,076,200.00	6,047,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал Үндсэн хөрөнгө	110,401,200.00	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал Бараа материал	16,675,000.00	6,047,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	263,784,750.81	82,867,769.91
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,249,429.57
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,249,429.57
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	742,445.46
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	263,784,750.81	80,618,340.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	846,986,420.00	1,072,886,005.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,051,600.00	13,270,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,051,600.00	13,270,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,051,600.00	13,270,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,051,600.00	13,270,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	839,934,820.00	1,059,616,005.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,838,320.00	81,333,405.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,720,000.00	87,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	15,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,268,400.00	23,106,242.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,849,920.00	43,140,163.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	821,096,500.00	978,282,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	821,096,500.00	978,282,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	651,116,960.00	920,325,705.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	651,116,960.00	920,325,705.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	501,165,576.07	835,644,157.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,809,327.00	475,469,611.48
210101	Үндсэн цалин	213,117,317.00	309,152,668.06
210102	Нэмэгдэл	45,099,196.00	112,394,471.33
210104	Урамшуулал	18,592,814.00	53,922,472.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,553,789.46	59,274,760.33
210201	Тэтгэврийн даатгал	24,057,018.13	40,368,895.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,664,806.17	4,779,492.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,067,659.86	3,819,194.35
210204	Ажилгүйдлийн даатгал	532,881.47	937,016.17
210205	Эрүүл мэндийн даатгал	5,231,423.83	9,370,161.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,380,495.07	69,957,838.88
210301	Гэрэл, цахилгаан	4,478,203.07	11,074,239.85
210302	Түлш, халаалт	54,998,192.00	57,385,599.00
210303	Цэвэр, бохир ус	904,100.00	1,498,000.03
2104	Хангамж, бараа материалын зардал	54,296,180.54	51,024,737.21
210401	Бичиг хэрэг	3,458,200.00	2,887,000.00
210402	Тээвэр, шатахуун	32,841,626.60	31,795,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,908,701.00	4,027,568.61
210404	Ном, хэвлэл	200,000.00	176,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,443,152.94	11,380,728.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	444,500.00	757,400.00
2105	Нормативт зардал	510,000.00	480,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	510,000.00	480,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,524,500.00	8,989,054.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,017,500.00
210602	Тавилга	140,000.00	00.00
210604	Урсгал засвар	15,384,500.00	4,971,554.00
2107	Томилолт, зочны зардал	2,892,200.00	3,395,000.00
210702	Дотоод албан томилолт	2,892,200.00	3,395,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,389,907.00	81,728,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,440,064.00	79,270,429.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	580,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	448,000.00	450,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,994.00	308,830.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	89,769.00	67,344.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	726,000.00	655,000.00
210807	Газрын төлбөр	394,080.00	396,637.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,809,177.00	85,324,916.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,514,873.00	83,864,916.05

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,294,304.00	1,460,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,951,383.93	84,681,547.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,454,000.00	12,545,959.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,612,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,374,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	5,920,959.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	467,500.00	6,625,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,497,383.93	72,135,588.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	115,497,383.93	72,135,588.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>195,869,460.00</u>	<u>152,560,300.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	195,869,460.00	152,560,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	195,869,460.00	152,560,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	195,869,460.00	152,560,300.00
223001	Бусад хөрөнгө	154,013,000.00	114,833,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,856,460.00	37,726,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-195,869,460.00</u>	<u>-152,560,300.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	234,148,626.22	156,351,697.25	00.00	1,093,647,155.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-252,610.27	00.00	-252,610.27
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	703,146,831.77	234,148,626.22	156,099,086.98	00.00	1,093,394,544.97
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	263,784,750.81	00.00	263,784,750.81
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	234,401,236.49	419,883,837.79	00.00	1,357,431,906.05
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	234,401,236.49	419,883,837.79	00.00	1,357,431,906.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,028,540.00	00.00	2,028,540.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	703,146,831.77	234,401,236.49	421,912,377.79	00.00	1,359,460,446.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,028,540.00	00.00	00.00	-2,028,540.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	80,618,340.34	00.00	80,618,340.34
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	232,372,696.49	502,530,718.13	00.00	1,438,050,246.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	830,552,600.00	782,633,111.95	47,919,488.05	94.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	830,552,600.00	782,633,111.95	47,919,488.05	94.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	818,743,600.00	771,087,152.95	47,656,447.05	94.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	476,585,700.00	475,469,611.48	1,116,088.52	99.8
210101	Үндсэн цалин	325,593,200.00	309,152,668.06	16,440,531.94	95.0
210102	Нэмэгдэл	115,992,500.00	112,394,471.33	3,598,028.67	96.9
210104	Урамшуулал	35,000,000.00	53,922,472.09	-18,922,472.09	154.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,573,200.00	59,274,760.33	298,439.67	99.5
210201	Тэтгэврийн даатгал	40,198,800.00	40,368,895.97	-170,095.97	100.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,843,700.00	4,779,492.72	64,207.28	98.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,874,700.00	3,819,194.35	55,505.65	98.6
210204	Ажилгүйдлийн даатгал	968,800.00	937,016.17	31,783.83	96.7
210205	Эрүүл мэндийн даатгал	9,687,200.00	9,370,161.12	317,038.88	96.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,000,000.00	69,957,838.88	42,161.12	99.9
210301	Гэрэл, цахилгаан	6,500,000.00	11,074,239.85	-4,574,239.85	170.4
210302	Түлш, халаалт	62,000,000.00	57,385,599.00	4,614,401.00	92.6
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,498,000.03	1,999.97	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	51,374,500.00	48,363,237.21	3,011,262.79	94.1
210401	Бичиг хэрэг	2,100,000.00	2,100,000.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	30,474,500.00	30,295,640.00	178,860.00	99.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,100,000.00	4,027,568.61	72,431.39	98.2
210404	Ном, хэвлэл	200,000.00	176,400.00	23,600.00	88.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,000,000.00	11,380,728.60	2,619,271.40	81.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	382,900.00	117,100.00	76.6
2105	Нормативт зардал	614,000.00	480,000.00	134,000.00	78.2
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	614,000.00	480,000.00	134,000.00	78.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	13,926,050.00	73,950.00	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,926,050.00	73,950.00	96.3
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	3,395,000.00	605,000.00	84.9
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	3,395,000.00	605,000.00	84.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,617,700.00	56,101,981.00	34,515,719.00	61.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,387,700.00	53,644,170.00	33,743,530.00	61.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,000.00	580,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.00	450,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	310,000.00	308,830.00	1,170.00	99.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.00	67,344.00	102,656.00	39.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	655,000.00	345,000.00	65.5
210807	Газрын төлбөр	720,000.00	396,637.00	323,363.00	55.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51978500.00	44118674.05	7,859,825.95	84.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,978,500.00	42,658,674.05	6,319,825.95	87.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	1,460,000.00	1,540,000.00	48.7

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11809000.00	11545959.00	263,041.00	97.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,809,000.00	11,545,959.00	263,041.00	97.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,184,000.00	5,920,959.00	263,041.00	95.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,625,000.00	5,625,000.00	00.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	160,880,000.00	136,783,900.00	24,096,100.00	85.0
2200	Дотоод эх үүсвэрээр	160,880,000.00	136,783,900.00	24,096,100.00	85.0
223001	Бусад хөрөнгө	160,880,000.00	136,783,900.00	24,096,100.00	85.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	991,432,600.00	919,537,011.95	72,015,588.05	92.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	978,282,600.00	906,147,011.95	72,135,588.05	92.6
132001	Орон нутгийн төсвөөс	978,282,600.00	906,147,011.95	72,135,588.05	92.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,150,000.00	13,270,000.00	-120,000.00	100.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,150,000.00	13,270,000.00	-120,000.00	100.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	26.00	02.00	92.9
620001	Удирдах ажилтан	09.00	09.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	12.00	02.00	85.7
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,333,405.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,333,405.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,333,405.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,661,500.00
210401	Бичиг хэрэг	787,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	374,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,973,004.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,017,500.00
210604	Урсгал засвар	4,955,504.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,492,659.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,492,659.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41206242.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,206,242.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81333405.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,333,405.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	87,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,106,242.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,140,163.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,038.3 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 5,038.3 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Оны төгсгөлд Хөвсгөл Үжин Пресс ХХК-руу мэдээллийн самбарын үнэ гэж 1,985.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч самбараа хийлгэж аваагүй, урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй, авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.6-д "бүх зардал" гэж заасныг зөрчсөн, Тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үнсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлыг 3,053.3 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна. Энэ нь Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 89,916.6 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс 9,731.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 80,185.6 мянган төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. ЗДТГ-ын алба хаагчид туршлага судлах нэрийдлээр Маркиза ХХК /Аяллын компани/-руу УБ-Жининь-Хөх хот чиглэлийн аяллын зардалд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 3,500.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1,154.1 мянган төгрөг, нийт 4,654.1 мянган төгрөг шилжүүлж, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Агар тэс эрдэнэ ХХК-руу шинэс модны суулгацын ажилд 1,940.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч шинэс мод тарьсан ажлын тайлан холбогдох материал байхгүй байхад санхүүжилт олгосон байна. Шалтгааныг тодруулахад тус компани шинэс мод тарих ажил гүйцэтгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.
3. ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Б.Мягмаржав /Засаг даргын орлогчоор ажиллаж байгаад/-д Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.2 дахь заалтыг үндэслэн ажлаас чөлөөлж, 3,136.9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон боловч мэргэжлийн шаардлага хангаагүй гэдгийг тогтоосон баримт байхгүй, энэ тухай ажилтанд өмнө нь анхааруулж, мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлээ сайжруулах боломжит хугацаа олгосныг нотлох баримт байхгүй тул тэтгэмж авахгүй байсан гэж үзэж төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт Төсвийг үнэн зөв, үндэслэлтэй төлөвлөөгүйгээс тайлант оны дундуур 311,602.2 мянган төгрөг нэмж тодотгосон, үүнээс орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 72,135.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэж заасныг баримтлаагүй байна.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цагаан-Уул сумын ЗДТГ-ын дотоод хяналтын нэгж нь тайлант онд хэрэгжүүлэх ажил төлөвлөөгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн эгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7.6-д “хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчлийг арилгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагаа болон санхүү бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах талаар хэрэгжих боломжтой зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцож, тайлагнаж, үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлж ажиллах.

Илрүүлэлт: Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас /213209/ ажилчдын шинэ жилийн бялуу, бэлгийн мөнгө 2,050.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах

Илрүүлэлт: Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт хөтөлбөрийн төсвийг төлөвлөх, зарцуулахдаа багийн төвийн өдөрлөг арга хэмжээний зардал гэж 6,000.0 мянган төгрөгийн тэмцээн уралдаан зохион байгуулж, өргөмжлөл, шагнал, медаль гардуулах зэрэг үр ашиггүй зардал төлөвлөж, зарцуулж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөхдөө сум орон нутагтаа зайлшгүй шаардлагатай, үр өгөөжтэй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хууль журмын дагуу зарцуулж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урьдчилж төлсөн зардал бүртгээгүй	1	1,985.0			1	1,985.0						
Хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон	1	3,053.3	1	3,053.3								
Дүн	2	5,038.3	1	3,053.3	1	1,985.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг үндэслэлгүй төлөвлөснөөс үлдэгдэл их байна.	1	72,135.6					1	72,135.6
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	4,654.1	1	4,654.1				
Гүйцэтгэгчээр ажиллаагүй, Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн	1	1,940.0	1	1,940.0				
Зориулалт бус тэтгэмж олгосон	1	3,136.9	1	3,136.9				
Дотоод хяналт хариуцлагатай холбоотой	1	0					1	0
Төсвийн үр ашигтай холбоотой	1	6,000.0					1	6,000.0
Эдийн засгийн ангилалтай холбоотой	1	2,050.0					1	2,050.0
Дүн	7	89,916.6	3	9,731.0			4	80,185.6